



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 5 сарын 25 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

XXII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXII хурал өргөтгөсөн хэлбэрээр 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 11:00 цагт Төрийн ордны “Жанжин Сүхбаатар”-ын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, Монгол Улсын Ерөнхий сайд холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ТАНИЛЦУУЛСАН:

1. 2020.05.25-ны өдрийн байдлаар коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдлын мэдээ;

*Халдварт өвчин судлалын төвийн
үндэсний төвийн дарга Д.Нямхүү*

2. Улсын онцгой комиссын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

*Монгол Улсын Шадар сайд
Улсын онцгой комиссын дарга
Ө.Энхтүвшин*

3. Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлын талаар;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Д.Сарангэрэл*

4. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед эдийн засгийг сэргээх хариу арга хэмжээний тухай;

*Сангийн сайд
Ч.Хүрэлбаатар*

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

7. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга
хошууч генерал Т.Бадрал*

8. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журмын талаар;

*Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга
бригадын генерал Г.Ариунбуян*

9. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад болзошгүй халдвараас хамгаалахад шаардагдах зардлын талаар;

*Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга
бригадын генерал Г.Ариунбуян*

10. Батлан хамгаалах яамны харьяа Цэргийн төв эмнэлэгт шаардагдах хөрөнгийн асуудал;

*Батлан хамгаалахын сайд
Улсын онцгой комиссын орлогч дарга
Н.Энхболд*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал,
Улсын онцгой комиссын гишүүн,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд сунгах, энэ асуудлаар хилийн боомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

1.2. Монгол Улсын Засгийн газраас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан тохиолдолд, Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үед КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох журмыг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлж Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;

1.3. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх зорилгоор сонгогчдын санал авах байрыг ариутгах, халдваргүйтгэл хийх, сонгогчид, сонгуулийн байгууллагын болон мэргэжлийн байгууллагын ажилтныг хамгаалах хэрэгслээр хангах, бусад шаардагдах зардлын асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх.

Хоёр. Улсын онцгой комиссын орлогч дарга,

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд,

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт:

2.1. Батлан хамгаалах яамны харьяа “Цэргийн төв эмнэлэг”-ийн үйл ажиллагааны зардалд үүссэн санхүүгийн алдагдлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх.

Дөрөв. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан нарт:

4.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед гадаад улсаас ирсэн иргэдийг хилийн боомт, төмөр замын өртөө, зөрлөг, нисэх онгоцны буудлаас эмнэлэг, тусгаарлах байр хүртэл, тусгаарлах байрнаас хот суурин газар хүртэл авто болон төмөр замаар тээвэрлэсэн тээвэрлэлтийн зардлыг тээврийн хэрэгслийн төрөл, ангиллаас хамааран холбогдох тариф, түр журмыг батлуулж, зардлыг тухайн иргэн өөрөө хариуцан холбогдох төрийн байгууллагын дансанд төвлөрүүлж, тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагад хуваарилан шилжүүлэх;

Тав. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Барилга, хот байгуулалтын сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Х.Баделхан,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан нарт:

5.1. “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2020 оны 164 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

5.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж бодис, оношлуур, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх.

5.3. Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулахад шаардлагатай нэмэлт санхүүжилтийн асуудлыг судлан, шийдвэрлүүлэх.

Зургаа. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал,
Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт:

6.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх шуурхай хариу арга хэмжээний багийг байгуулж, бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, заавар зөвлөмжөөр хангах;

Долоо. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал нарт:

7.1. 2020 оны 6, 7 дугаар сард гадаад улс орнуудаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах төлөвлөгөө боловсруулж Улсын онцгой комиссын даргаар батлуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллах;

Найм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт:

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан элсэлтийн ерөнхий шалгалтын сэдэв, даалгавар боловсруулах, хэвлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 7 дугаар сарын 05-ны өдрийг дуустал тусгайлан бэлтгэсэн объектод ажиллуулах.

Ес. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,
Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Улсын онцгой комиссын гишүүн бригадын, генерал С.Баатаржав,
Гаалийн ерөнхий газрын дарга,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,
Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин,
Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар
Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил,
улс хоорондын ачаа тээвэрлэлт эрхэлдэг аж ахуйн нэгж,
байгууллагын захирал нарт:

9.1. Улсын онцгой комиссын даргын баталсан “Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ыг боловсронгуй болгож зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9.2. Монгол Улс – БНХАУ-ын хилийн авто замын боомтуудад уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

ДАРГА,
ШАДАР САЙД

Ө.ЭНХТҮВШИН

НАРИЙН БИЧГИЙН, УХА0169
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.САНЖАА